

15. Чэнь и тухайбал Цэрэндоржоос тавьсан Богд хааны хэргэм зэрэг шагнах эрх ба барга өвөр монголчуудын Халхад чөлөөтэй нэвтэрч байх эрхийг хэвээр хадгалах саналыг хүлээж аваагүй.
16. Мөн тэнд. л. 178.
17. 1919 оны 4 сарын 13-нд Хүрээний засгийн газар нармай монголын хөдөлгөөний тэргүүлэгчдээс 1919 оны 3 срад Читад тунхагласан тусгаар тогтносон нэгдмэл монгол улсад Гадаад монголыг нэгдэхийг хүссэн хүсэлтийг няцааж 1915 оны Хиагтын гэрээнд үнэнч гэдгээ мэдэгдсэн.
18. Мөн тэнд.л. 179.
19. Мөн тэнд.л. 179-180.
20. Мөн тэнд.л. 180.
21. Мөн тэнд.л.181-182.
22. Мөн тэнд.л. 182.
23. Миний бичсэн «Урианхай хязгаарын төлөө тэмцэл. 1915 1919 он» гэсэн өгүүлэл «эх орны түүх» сэтгүүлд 1996 онд нийтлэгдэнэ.
24. Мөн тэнд.л. 182-183.
25. Мөн тэнд.л. 97-100.
26. «Чжэнфу гунбао» 1919 оны 11 сарын 23. Мөн тэнд.л.101.
27. АВПРИ, Ф. Бээжин дэх төлөөлөгчийн газар. д 324.л. 112.
28. Мөн тэнд. л. 113.
29. Кудашёваас Сукинд илгээсэн нууц цахилгаан. 1919 оны 11 сарын 28.
30. С.Д. Сарзановоос Сукинд илгээсэн нууц цахилгаан. 1919 оны 12 сарын 16, мөн тэнд. д. 445, л. 130. С.Д. Сазанов 1910-1915 онд Оросын гадаад явдлын яамны сайд, 1918-1920 онд Парисын энх тайвны бага хуралд А.В.Колчак ба А.И. Деникиний засгийн газрыг төлөөлж байсан
31. АВПРИ, Ф. Бээжин дэх төлөөлөгчийн газар. д 324.л. 197.
32. Мөн тэнд. л.193.

МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН АШИГЛАЛТ,
ЦААШДЫН ХЭРЭГЦЭЭ

О.Батсайхан.*

Дэлхий дахинд өрнөсөн их өөрчлөлт шинэчлэлийн урсгалд Монгол улс 1990 оноос алхаа нэгдэн орсон билээ. Энэ үе нь социалист систем задарч, ЗХУ бутарсан үетэй давхацсан нь ЗХУ-ын болон ЭЗХТЗ-ийн тусламж дэмжлэгт түшиглэн оршиж байсан

* Гадаад харилцааны Яамны ажилтан

Монгол орны хувьд туйлын хүндээр туссан юм.

Чухам энэ хүнд үед ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих өөрчлөлт, шинэчлэлийн замыг сонгон авч түүнийг хугацаа хожин хэрэгжүүлэх зорилт тавьсан Монгол улсын засгийн газрын хүч чармайлтыг дэмжсэн хандивлагчдын хөдөлгөөн үүсч бидэнтэй хамтран ажиллаж эхэлсэн билээ.

1991 оноос хойш хандивлагчаас үзүүлсэн зээл тусламж нь Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжих зорилтыг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлж байна. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих талаар Засгийн газраас тавьж буй чармайлт, хандивлагчдаас үзүүлж буй тусламж, дэмжлэгийн үр дүнд монголын эдийн засагт нааштай ахиц дэвшил гарч байна.

Шилжилтийн эхний үед хандивлагчдаас үзүүлсэн дэмжлэг туслалцаа нь эдийн засгийн уналтыг зогсоон тогтворжуулахад чиглэсэн яаралтай арга хэмжээнд чиглэж байсан бол одоо цаашдын хөгжлийн үндэс бүтцийг хөгжүүлэхэд илүүтэй чиглэж байна. Үйлдвэрлэлийн дэд бүтцийг хөгжүүлэхэд түлхүү анхаарч байгаагийн дүнд түлш эрчим хүч, зам тээвэр, холбооны салбарт ерөнхий төлөвлөгөө боловсрогдож түүнд тусгагдсан гол гол томоохон төслүүд хэрэгжиж эхлэв. Эхний үр дүн ч мэдрэгдэж эхэллээ. Энэ бол хандивлагчдын дэмжлэг туслалцаа, хамтын чармайлтын үр дүн мөн билээ.

Өнөөдөр манай улс бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх, нийгмийн секторт хуримтлагдсан хүндрэл бэрхшээлийг гэтлэх, үндэсний боловсон хүчний чадавхийг дээшлүүлэхэд хүч анхаарлаа төвлөрүүлж байна. Юуны өмнө:

- Эдийн засагт бий болсон макро түвшингийн тогтворжилтыг бататгахын тулд ОУВС болон бусад олон улсын байгууллагатай тохирсон бодлогын арга хэмжээг эрчимжүүлэх, эдийн засаг, санхүү, мөнгөний эрүүл орчин бүрэлдүүлэх, үйлдвэрлэгчдийн санхүүгийн чадавхийг сайжруулж үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлэх, цаг агаар, улирлын хамаарлыг гэтлэх, улсын төсвийн болон төлбөрийн тэнцлийг сайжруулахад чиглэсэн дэс дараатай арга хэмжээ авах

- Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэхийн тулд үйлдвэрлэлийн дэд бүтцийг түрүүлэн хөгжүүлэх замаар ажил амьдралын хэвийн нөхцөл бүрэлдүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээ өргөжих таатай орчин бий болгох

- Ард иргэдийн амьжиргааны түвшингийн уналтыг зогсоох, ажилгүйдэл, ядуурлын түвшинг бууруулах замаар нийгмийн салбарт хуримтлагдсан хүндрэл бэрхшээлийг гэтлэхэд чиглэгдсэн арга хэмжээг эрчимжүүлэх шаардлага хурцаар тавигдаж байна. Нийгмийн салбарт өмнөх жилүүдэд хүрсэн түвшинг сэргээх зорилгоор нийгмийн дэд бүтцийн салбаруудын хөгжлийг дэмжихэд төр, засгийн байгууллагуудын анхаарлыг төвлөрүүлэх
- Шинэ нөхцөлд ажиллах чадвартай, үндэсний боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, төрийн захиргааны байгууллагуудын өөрчлөлт шинэчлэлтийг хийх, улсын болон хувийн секторын удирдлагын чадавхийг дээшлүүлэх зэрэг олон чухал ажил тулгарч байна.

Үүнээс үзэхэд Монгол улсын хувьд хандивлагчдаас үзүүлэх дэмжлэг, тусламцааг үргэлжлүүлэн авах шаардлага ойрын жилүүдэд хэвээр байх нь тодорхой байна.

Хандивлагчдаас Монголд үзүүлж буй дэмжлэг тусламжийн үр өгөөжийг дээшлүүлэх, зээл тусламжийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудал, ирээдүйн зорилтыг хэрэгжүүлэхэд үр дүнтэй ашиглах асуудал нэн чухал юм.

Хандивлагчдын тусламж, дэмжлэгийг эдийн засаг, нийгмийн цаашдын хөгжлийн суурь тавих, үйлдвэрлэлийн дэд бүтцийг хөгжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд тэргүүн ээлжинд зориулах зарчим баримталж бодлого тодорхойлох, төсөл арга хэмжээг сонгох, эрэмбэ дараалал тогтоох, хэрэгжилтийг хянаж зохион байгуулах, уялдуулан зохицуулахад анхаарал төвлөрүүлж байна.

Төсөл, арга хэмжээг сонгохдоо тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, цаашдын хөгжлийн баттай суурь тавих, ирээдүйд харилцан үр ашигтай хамтран ажиллах нөхцөл бүрдүүлэхэд ач холбогдол өгч байна.

Хандивлагчдаас олгосон хөнгөлөлттэй зээлийг графикт хугацаанд нь барагдуулах потенциал бий болгох, Монгол орны экспортын чадавхийг нэмэгдүүлэх асуудалд одооноос анхаарал төвлөрүүлэх нь зүйтэй юм.

Гадаадын зээл, тусламжийг тодорхойлох үндсэн хэлбэр нь 1991 оноос хойш жил бүр Токио хотноо болж байгаа Монголыг дэмжигч орнуудын зөвлөлдөх уулзалт болно. Үүнээс гадна хоёр талын шугамаар хандивлагчид нэмэлт амлалт хийж байна. 1991-1995 он хандивлагчдаас амалсан зээл, тусламжийг тусламжийн бүх

хэлбэрээр (төслийн, техникийн туслалцааны, санхүүгийн тооцоход 1.230.7 сая ам.доллар болж байна. Нийт амлагдсан зээл, тусламжийн 40 хувийг буцалтгүй тусламж эзэлнэ.

Хүснэгт 1
/сая ам.доллар/

Бүтэц	1991	1992	1993	1994	1995	Нийт
Төслийн хэлбэрийн тусламж	14.4	111.3	167.3	119.4	207.0	619.4
Төлбөрийн балансыг дэмжих	139.5	60.5	173.9	30.3	47.5	451.7
Техник туслалцаа	20.5	28.6	35.3	33.2	42.0	159.6
Нийт	174.4	200.4	376.5	182.9	296.5	1230.7

Гадаадын зээл, тусламжийн хөтөлбөрийн бүтцэд яаралтай тусламжийн хувийн жин буурч хөгжлийн дунд болон урт хугацааны төслийг санхүүжүүлэх хэлбэрийн хувийн жин өсч байна. Энэ нь эдийн засгийн уналт, хямрал зогсож, цаашдын хөгжлийн үндсийг тавих асуудалд анхаарлаа хандуулах болсонтой холбоотой гэж үзэж байна. Эдийн засаг тогтворжиж байгаагийн үр дүнд барааны болон санхүүгийн (төлбөрийн балансыг дэмжих) тусламжийн хэмжээ буурч улмаар төслийн болон техник туслалцааны цар хүрээ өсч байна.

Өнгөрсөн хугацаанд хандивлагчдын амалсан зээл тусламжийн 62 хувийг ашиглаад байна. Гадаадын зээл тусламжийг салбараар авч үзвэл 1991-1995 онд эрчим хүчний салбарт 110 гаруй сая ам. доллар, тээврийн салбарт 84 орчим сая ам.доллар зээл тусламжийг тус тус авч ашигласан буюу дэд бүтцийн салбарт нийт ашигласан зээл тусламжийн 40 орчим хувийг зарцуулсан байна.

Хүснэгт 2
/сая ам.доллар/

Салбар	Амлалт	хувь	Ашиглалт	Хувь
А. Үйлдвэрийн дэд бүтэц	500.5	40.7	217.2	28.3
- Түлш, эрчим хүч	241.7	19.7	110.4	14.4
- Зам, тээвэр	197.0	16.1	83.8	10.9
- Холбоо	60.5	4.9	21.9	2.9
- Усан хангамж	1.2	0.0	1.1	0.1

- Нийгмийн хөгжил	17.6	1.4	4.8	0.5
В. Аж үйлдвэр	56.4	4.6	31.2	4.1
Г. Хөдөө аж ахуй	51.9	4.2	28.9	3.8
Д. Байгаль орчин хамгаалал	10.2	0.8	6.6	0.9
Е. Удирдлагын хөгжил	59.1	4.8	27.2	3.5
Ё. Төлбөрийн балансыг дэмжих	451.7	36.8	389.2	50.8
Ж. Бусад	1.0	0.0	0.6	0.0
Дүн	1230.7	100.0	766.4	100.0

Амлагдсан зээл тусламжийн ашиглалтын түвшин доогуур байгаа нь сүүлийн жилүүдэд амалсан зээл тусламж үндсэндээ урт хугацааны төсөл хэрэгжүүлэхэд чиглэж байгаа бөгөөд судалгаа хийх, төсөл хэрэгжүүлэхэд харьцангуй урт хугацаа шаардлагатай байдагтай холбоотой. Үүний дээр дотоод зохицуулалт, бэлтгэл хангах ажлын үр дүн сайнгүй байгааг тэмдэглэх хэрэгтэй.

ХХ ЗУУНЫ ЭХНИЙ МОНГОЛ, ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ТӨЛӨВ БАЙДЛААС

Ц.Цэрэнлхам

1.Оросын худалдааны иргэд монголд нэвтэрсэн нь.

Монгол, Оросын худалдааны харилцаа бүр эртний түүхтэй.1689 оны Нэрчүүгийн гэрээгээр Орос, Хятадын засгийн газрын хооронд худалдаа хийхийг албан ёсоор зөвшөөрсөн нь Монгол нутагт Оросын худалдаачид ирж суурьших эх үүсвэрийг тавьжээ. ХҮИИ зуунаас эхлэн Хятад цайг Оросоор дамжуулан Европд оруулах болсон нь Монголд Орос иргэд ирэх явдлыг улам түргэсгэв. XIX зууны I хагасаас оросын худалдаачид Өргөө зэрэг хот суурин газар төдийгүй хөдөө нутгаар ирж суурьших болов.Орос иргэдийн анхны суурьшигчид нь хуучин шүтлэгтнүүд голдуу байв. Дараа нь оросын худалдаачид ирж эхэлсэн байна. 1860 онд Өргөө хотноо Оросын анхны худалдааны пүүс нээгджээ. Дараа нь Улиастай, Ховд хотууд болон хошуу нутгуудаар тарж эхэлсэн байна. Ялангуяа 1911-1912 оны эргэлтийн дараа оросууд мэдэгдэхүйц олширчээ. 1912-1919 онуудад тэдний тоо 1500-5000 хүртэл өссөн байна. 1919-1920 оны тоогоор Өргөөд 3000, Ховдод 300, Хатгалд 150, Улиастайд 100, Заяын шавьд 100, Вангийн хүрээнд 60, Мөрөнд 50, Хангилицыцагт 40 орос иргэн аж төрж байсан байна. Монголд суурьшсан худалдаачид ихэвчлэн Бийск - болон Хиагт хотоос гаралтай байв. Газар зүйн байрлалтайгаа уялдуулан Бийск хотоос ирсэн. наймаачид нь голчлон баруун Монголд / Ховд, Улиастай болон түүний ойр орчмоор, Хиагт хотоос ирсэн нь Өргөө болон Заяны шавьд амьдарч байжээ.